



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 9 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2023/35-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.open.audit.mn

Дархан сум
2023 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр

Утас: 70373089, 99023682

Цахим хаяг: Munkhbayarsh@audit.gov.mn

Аудитын менежер: У.Батсүрэн

Утас: 99036806 Цахим хаяг: Batsurenu@audit.gov.mn

Аудитын гүйцэтгэсэн: ЦЭСБ-Аудит ХХК

Утас: 95112689 Цахим хаяг: tsesb.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ДАРХАН-УУЛ АЙМГАТ ДАМЬ
ҮӨРИЙН АУДИТЫН САЛААР**

Бүтэцтэй гэдгээр 14 дүгээр 90 Дархан-Уул
Дархан-Уул аймгаас 41000
Уул 7011-5000 Факс: 070-70115000
Улаанбаатар - Дархан-Уул аймгийн дархан сум
Төрийн аудитын салбар

2022.02.25

20

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 6 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 9 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ

Дархан-Уул аймгийн Дархан сумын 9 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв тогилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ес зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Дархан сумын 9 дүгээр сургуулийн 2022 оны нийт төсвийн зарцуулалт, ажил гүйлгээний 80.1 хувийг цалин хөлс, нэмэгдэл урамшуулал болон ажил олгогчоос төлөх НДШ, 2.2 хувийг байр ашиглалттай холбоотой тогтмол зардал тус тус эзэлж байна.

Аудитын гол асуудал

Дархан сумын 9 дүгээр сургууль нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн А/343 дугаар тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр тавдугаар түвшинд үнэлэгдэж, урамшуулал санхүүжилт аваагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Дархан сумын 9 дүгээр сургууль нь байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 1 зорилтын хүрээнд 13 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 92.2 хувиар биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	92,002,004.00	326,149,672.99
31	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	-	229,171,840.23
311	Кассанд байгаа	-	
312	Банкинд байгаа		229,171,840.23
33	АВЛАГА	-	-
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага		
35	БАРАА МАТЕРИАЛ	92,002,004.00	96,977,832.76
351	Түүхий эд материал	84,403,159.00	2,106,385.00
35110	Тусгай зориулалттай материал	80,735,029.00	-
35130	Эм боох материал	3,668,130.00	2,106,385.00
354	Хангамжийн материал	7,598,845.00	94,871,447.76
35410	Бичиг хэргийн материал	3,660,900.00	867,200.00
35420	Аж ахуйн материал	1,363,285.00	1,296,320.00
35450	Барилгын засварын материал	2,574,660.00	3,652,050.00
35460	Хүнсний материал		
35470	Бусад хангамжийн материал	-	89,055,877.76
356	Мал амьтад	-	-
36	НӨӨЦИЙН БАРАА		
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,502,542,462.56	3,480,648,006.86
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,502,542,462.56	3,480,648,006.86
392	Биет хөрөнгийн дүн	2,106,477,387.68	2,079,154,006.86
39201	Барилга байгууламж	1,888,342,950.30	1,888,342,950.30
39202	Хуримтлагдсан элэгдэл	(230,419,510.08)	(307,733,082.84)
39205	Машин тоног төхөөрөмж	322,068,121.49	449,507,701.49
39206	Хуримтлагдсан элэгдэл	(117,225,291.98)	(168,042,805.55)
39207	Тавилга, эд хогшил	166,806,079.46	197,240,879.46
39208	Хуримтлагдсан элэгдэл	(66,837,975.23)	(91,404,782.15)
39214	Бусад үндсэн хөрөнгө	141,418,844.23	141,153,847.83
39215	Хуримтлагдсан элэгдэл	(73,518,941.08)	(95,582,752.88)
39217	Ном	75,843,110.57	65,672,051.20
393	Биет бус хөрөнгийн дүн	1,396,065,074.88	1,401,494,000.00
39301	Программ хангамж	9,332,300.00	16,332,300.00
39302	Хасагдуулга	(7,467,225.12)	(9,038,300.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	1,394,200,000.00	1,394,200,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,594,544,466.56	3,806,797,679.85
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,594,544,466.56	3,806,797,679.85
51	Засгийн газрын хувь оролцоо	3,594,544,466.56	3,806,797,679.85
511	Засгийн газрын оруулсан капитал	2,135,615,316.43	3,594,544,466.56
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө		3,594,544,466.56
51101	Өмч: -төрийн	2,135,615,316.43	-
512	Хуримтлагдсан үр дүн	(746,314,916.63)	212,253,213.29
51210	Өмнөх үеийн үр дүн	(746,314,916.63)	-
51220	Тайлант үеийн үр дүн		212,253,213.29
51300	Дахин үнэлгээний зөрүү	2,205,244,066.76	-
6	ӨР ТӨЛБӨР БА ЭЗ/ӨМЧИЙН ДҮН	3,594,544,466.56	3,806,797,679.85

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,923,532,719.57	3,130,958,497.76
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	22,993,208.77	123,156,435.76
120	Нийтлэг татварын бус орлого	22,993,208.77	123,156,435.76
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,464,010.00	31,613,393.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		10,344,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,464,010.00	11,929,413.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого		9,339,380.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	17,532,584.68	82,282,514.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	2,996,614.09	9,260,528.76
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,900,539,510.80	3,007,802,062.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,836,581,600.00	2,880,710,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		2,880,710,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүдгээс санхүүжих	1,836,581,600.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,741,041.80	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хувиарласан хөрөнгө	12,473,041.80	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	268,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	51,216,869.00	127,091,762.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	51,216,869.00	127,091,762.00
2	Үйл ажиллагааны зардал	2,087,515,379.79	2,898,371,711.10
21	Урсгал зардал	2,087,515,379.79	2,898,371,711.10
210	Бараа, үйлчилгээний зардал	2,002,445,752.79	2,603,180,376.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	1,533,644,933.00	1,984,200,282.00
210101	Үндсэн цалин	941,296,949.00	1,339,046,622.00
210102	Нэмэгдэл цалин	496,445,784.00	521,788,027.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,149,000.00	
210104	Урамшуулал	93,753,200.00	97,286,209.00
210105	Гэрээт ажлын хөлс		26,079,424.00
2102	Нийгмийн даатгалын шимтгэл	202,327,534.00	249,974,918.87
210201	Тэтгэврийн даатгалын	141,454,777.19	171,704,750.62
210202	тэтгэмжийн даатгалын	15,735,571.33	20,201,871.15
210203	ҮОМШӨ-ий даатгалын	12,319,657.01	15,879,256.87
210204	Ажилгүйдлийн даатгалын	2,983,411.75	3,834,744.49
210205	ЭМ-ийн даатгалын	29,834,116.72	38,354,295.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,684,378.00	61,443,698.78
210301	Гэрэл цахилгааны зардал	7,143,944.00	12,877,848.00
210302	Түлш, халаалтын зардал	28,490,517.00	36,432,666.75
210303	Цэвэр бохир усны зардал	5,049,917.00	12,133,184.03
210304	Байрны түрээс		
2104	Хангамж, бараа материалын зардал	7,174,672.00	14,298,785.00

210401	Бичиг хэргийн зардал	854,800.00	604,000.00
210404	Тээвэр шатахуун	545,500.00	
210403	Шуудан, холбоо, интернэтийн зардал	2,310,337.00	290,400.00
210404	Ном, хэвлэл	289,100.00	
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	2,171,350.00	2,747,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,003,585.00	6,617,205.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	4,039,480.00
2105	Нормативт зардал	5,070,501.80	3,913,293.86
210501	Эм, бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	3,584,501.80	2,621,895.86
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,486,000.00	1,291,398.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,172,970.00	16,033,100.00
210604	Урсгал засварын зардал	10,172,970.00	16,033,100.00
2107	Томилолтын зардал	-	216,000.00
210702	Дотоодын томилолт	-	216,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын хөлс	1,577,400.00	20,253,733.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	-	10,344,600.00
210802	Аудит баталгаажуулалтын зардал	924,900.00	924,000.00
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	652,500.00	8,985,133.00
2109	Бараа, үйлчилгээний бусад зардал	201,793,363.99	252,846,565.37
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	545,700.00	34,966,079.04
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	14,175,544.84	29,313,810.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	187,072,119.15	188,566,676.33
213	Урсгал шилжүүлэг	85,069,627.00	295,191,334.22
2132	Бусад урсгал шилжүүлэг	69,941,800.00	281,020,500.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж		
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	68,191,800.00	281,020,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		
213209	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	1,750,000.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	30,801.00	14,170,834.22
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,801.00	14,170,834.22
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	15,097,026.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,097,026.00	-
3	Үйл ажиллагааны үр дүн	(163,982,660.22)	232,586,786.66
145	Үйл ажиллагааны бус орлогын дүн		
225	Үйл ажиллагааны бус зардлын дүн		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	20,333,573.37
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	20,333,573.37
4	Үйл ажиллагааны бус үр дүн	-	(20,333,573.37)
5	Үйл ажиллагааны нийт үр дүн	(163,982,660.22)	212,253,213.29

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,903,003,520.80	3,030,076,075.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,464,010.00	22,274,013.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,464,010.00	22,274,013.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	2,464,010.00	22,274,013.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих		10,344,600.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,464,010.00	11,929,413.00
13	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,900,539,510.80	3,007,802,062.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,836,581,600.00	2,880,710,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт		2,880,710,300.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,836,581,600.00	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,741,041.80	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хувиарласан хөрөнгө	12,473,041.80	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	268,000.00	-
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	51,216,869.00	127,091,762.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	51,216,869.00	127,091,762.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,899,255,520.80	2,705,520,334.77
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,899,255,520.80	2,705,520,334.77
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,814,185,893.80	2,410,329,000.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	1,533,644,933.00	1,984,200,282.00
210101	Үндсэн цалин	941,296,949.00	1,339,367,475.00
210102	Нэмэгдэл	496,445,784.00	521,267,174.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,149,000.00	
210104	Урамшуулал	93,753,200.00	95,086,209.00
210105	Гэрээт ажлын хөлс		28,479,424.00
2102	Ажил олгогчийн нийгмийн даатгалд төлөх шимтгэл	202,327,534.00	249,974,918.87
210201	Тэтгэврийн даатгалын	141,454,777.19	171,704,750.62
210202	Тэтгэмжийн даатгалын	15,735,571.33	20,201,871.15
210203	ҮОМШӨ-ий даатгалын	12,319,657.01	15,879,256.87
210204	Ажилгүйдлийн даатгалын	2,983,411.75	3,834,744.49
210205	Эрүүл мэндийн даатгалын	29,834,116.72	38,354,295.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	40,684,378.00	61,443,698.78
210301	Гэрэл цахилгааны зардал	7,143,944.00	12,877,848.00
210302	Түлш, халаалтын зардал	28,490,517.00	36,432,666.75
210303	Цэвэр бохир усны зардал	5,049,917.00	12,133,184.03
2104	Хангамж, бараа материал	8,609,167.00	-
210401	Бичиг хэргийн зардал	990,310.00	
210404	Тээвэр шатахуун	545,500.00	
210403	Шуудан холбооны зардал, мэдээлэл тех-гийн үйлчилгээ	1,485,337.00	
210404	Ном	281,100.00	
210405	Хог хаягдал устгах, цэвэрлэх	2,602,950.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,703,970.00	
210408	Бараа материал акталсны зардал		
2105	Нормативт зардал	3,294,351.80	-
210501	Эм	2,288,851.80	
210502	Хоол, хүнс	-	
210503	Нормын хувцас	1,005,500.00	
2106	Эд хогшил урсгал засвар	9,901,690.00	16,574,280.00
210604	Урсгал засвар	9,901,690.00	16,574,280.00

2107	Томилолт, зочны зардал	-	-
210702	Дотоодын томилолт		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажлын, үйлчилгээний төлбөр, хураамж	1,577,400.00	19,329,733.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил , үйлчилгээний төлбөр, хураамж	-	10,344,600.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	924,900.00	
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	652,500.00	8,985,133.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	14,146,440.00	78,806,087.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	545,700.00	53,475,027.90
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	13,600,740.00	25,331,060.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	85,069,627.00	295,191,334.22
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг		
2132	Бусад урсгал шилжүүлэг	69,941,800.00	281,020,500.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр тэтгэмж		
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшуулал	68,191,800.00	281,020,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		
213208	Хөдөө орон нутагт тогтвортой ажилласан а/хаагчдад дэмжлэг		
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	1,750,000.00	-
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт , шилжүүлэг	-	-
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	30,801.00	14,170,834.22
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	30,801.00	14,170,834.22
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэлт	15,097,026.00	-
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,097,026.00	
3	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	3,748,000.00	324,555,740.23
	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
4	Хөрөнгө оруулалтын мөнгөн орлогын дүн		
5	Хөрөнгө оруулалтын мөнгөн зарлагын дүн	3,748,000.00	95,383,900.00
22	Хөрөнгийн зардал	3,748,000.00	95,383,900.00
2200	Дотоод эх үүсвэрээр	3,748,000.00	95,383,900.00
223001	Бусад хөрөнгө	3,748,000.00	95,383,900.00
6	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(3,748,000.00)	(95,383,900.00)
7	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх		
8	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	229,171,840.23
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		229,171,840.23

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны үр дүн
А	1	2	3	4
2020 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	2,135,615,316.43	2,205,244,066.76	(746,314,916.63)	3,594,544,466.56
НББ-ийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				-
ҮХ-ийн өсөлт, бууралт				-
ҮХ-ийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн				-
2021 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	2,135,615,316.43	2,205,244,066.76	(746,314,916.63)	3,594,544,466.56
НББ-ийн бодлогын өөрчлөлт			746,314,916.63	746,314,916.63
ҮХ-ийн өсөлт, бууралт	1,458,929,150.13			1,458,929,150.13
ҮХ-ийн дахин үнэлгээний бууралт		(2,205,244,066.76)		(2,205,244,066.76)
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			212,253,213.29	212,253,213.29
2022 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	3,594,544,466.56	-	212,253,213.29	3,806,797,679.85

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	3,026,381,700.00	2,786,733,400.55	239,648,299.45	92.1
21	Урсгал зардлын дүн	3,026,381,700.00	2,786,733,400.55	239,648,299.45	92.1
210	Бараа үйлчилгээний зардал	2,723,404,000.00	2,786,733,400.55	(63,329,400.55)	102.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,125,034,500.00	1,984,200,282.00	140,834,218.00	93.4
210101	Үндсэн цалин	1,496,784,000.00	1,339,367,475.00	157,416,525.00	89.5
210102	Нэмэгдэл	559,297,700.00	521,267,174.00	38,030,526.00	93.2
210104	Урамшуулал	40,473,300.00	95,086,209.00	(54,612,909.00)	234.9
210105	Гэрээт ажлын хөлс	28,479,500.00	28,479,424.00	76.00	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	265,653,900.00	249,974,918.87	15,678,981.13	94.1
210201	Тэтгэврийн даатгал	180,771,100.00	171,704,750.62	9,066,349.38	95.0
210202	Тэтгэмжийн даатгал	21,267,200.00	20,201,871.15	1,065,328.85	95.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,000,300.00	15,879,256.87	1,121,043.13	93.4
210204	Ажилгүйдлийн даатгал	4,237,800.00	3,834,744.49	403,055.51	90.5
210205	ЭМД-ын хураамж+В21	42,377,500.00	38,354,295.74	4,023,204.26	90.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	71,754,600.00	61,443,698.78	10,310,901.22	85.6
210301	Гэрэл цахилгааны зардал	14,154,600.00	12,877,848.00	1,276,752.00	91.0
210302	Түлш, халаалтын зардал	45,900,000.00	36,432,666.75	9,467,333.25	79.4
210303	Цэвэр бохир усны зардал	11,700,000.00	12,133,184.03	(433,184.03)	103.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	16,800,000.00	16,574,280.00	225,720.00	98.7
210601	Багаж хэрэгсэл	-	-	-	-
210602	Тавилга				
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл				-
210604	Урсгал засвар	16,800,000.00	16,574,280.00	225,720.00	98.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	36,006,300.00	26,329,733.00	9,676,567.00	73.1
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр	10,344,600.00	10,344,600.00	-	100.0
210806	Мэдээлэл технологийн үйлчилгээ	25,661,700.00	15,985,133.00	9,676,567.00	62.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	208,154,700.00	167,189,987.90	40,964,712.10	80.3
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	169,662,100.00	131,340,327.90	38,321,772.10	77.4

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	38,492,600.00	35,849,660.00	2,642,940.00	93.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	302,977,700.00	281,020,500.00	21,957,200.00	92.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	302,977,700.00	281,020,500.00	21,957,200.00	92.8
213205	Төсвөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	302,977,700.00	281,020,500.00	21,957,200.00	92.8
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,026,381,700.00	3,015,905,240.78	10,476,459.22	99.7
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,880,710,300.00	2,880,710,300.00	-	100.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,880,710,300.00	2,880,710,300.00	-	100.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих			-	
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	127,092,500.00	112,920,927.78	14,171,572.22	88.85
132001	Орон нутгийн төсвөөс	127,092,500.00	112,920,927.78	14,171,572.22	88.85
120	ТӨСӨВТ БАЙГУУЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	18,578,900.00	22,274,013.00	(3,695,113.00)	119.9
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос	10,344,600.00	10,344,600.00	-	100.0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос	8,234,300.00	11,929,413.00	(3,695,113.00)	144.9
	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	229,171,840.23		
001	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			-	
002	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.0
003	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.0
	АЖИЛЛАГСАДЫН ТОО	121.00	128.00	(7.00)	105.8
	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.0
	Гүйцэтгэх ажилтан	105.00	112.00	(7.00)	106.7
	Үйлчлэх ажилтан	15.00	15.00	-	100.0
010	СУРАЛЦАГЧДЫН ТОО /ЖИЛИЙН ДУНДЖААР/	2,400.00	2,403.00	(3.00)	100.1
015	Төрийн өмчит СӨБ байгууллага	2,400.00	2,403.00	(3.00)	100.1
024	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ			-	
028	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч /ТҮБД/	101.00	108.00	(7.00)	106.9
033	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч	20.00	20.00	-	100.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Дархан сумын Ерөнхий боловсролын 9 дүгээр сургууль нь “Хүүхдийн хөгжлийг дэмжих, тэдний хүмүүжил төлөвшилд эцэг эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хамтын ажиллагааг сайжруулах, “Сурлагын хоцрогдоог арилгах”, амжилттай суралцахад сургалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулах, ЭЕШ-ийн дүнд ахиц гаргах, сурлага хүмүүжлийн хоцрогдолгүй хамт олон болох” гэсэн эрхэм зорилгыг хүрээнд явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сургалтыг тасралтгүй үргэлжлүүлэх бэлэн байдлыг хангах, цахим хичээлийн сан, бие даан ажиллах дасгал, даалгаврын санг судлагдхуун бүрээр гаргаж, үр дүнтэй ашиглах
- Дижитал технологийг сургалтын үйл ажиллагааны үндсэн хэрэгсэл болгохын тулд ЗАН-ээрээ, судлагдхуунаараа хамтран ажиллах, тасралтгүй хөгжих боломжийг бий болгох,
- Хүүхэд бүрийн онцлог, ялгаатай хэрэгцээг судлан оношлох, тэдний сурах, хөгжих үйлийг дэмжих, тэгш оролцоог хангах, хамтран суралцах соёлыг төлөвшүүлэх
- Багш ажилтанд стрессээс сэргийлэх сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, ажлын байранд эерэг уур амьсгал бүхий байгууллагын соёлыг бий болгох
- Сургалт, хүмүүжлийн үйл ажиллагааг улирлан байдлаас үл хамааран гадна орчинд зохион байгуулах эхлэлийг тавих
- Дунд, ахлах ангийн суралцагч ажил мэргэжлийн чиг баримжаатай болох, мэргэжлээ зөв сонгоход төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилтийг баталсан,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн байна.
- Төрийн хэмнэлтийн тухай тухай хууль хэрэгжиж эхэлсэн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон.
- Боловсролын тухай хуульд 2022 онд 3 удаа нэмэлт өөрчлөлт орсон,
- ЗГ-ын 2022 оны 91 дүгээр тогтоолоор батлагдсан “Хувьсах зардлын дундаж норматив, аргачлал батлах тухай” журам хэрэгжиж эхэлсэн,
- ЗГ-ын 2019 оны 472 дугаар тогтоолын 5, 6 дугаар хавсралтаар батлагдсан “Шинжлэх ухааны байгууллага, сургуулийн өмнөх болон бага, дунд

боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын цалингийн сүлжээ батлах тухай ” тогтоолд 2022 оны 107 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” тогтоол, 2022 оны 192 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,

- ЗГ-ын 2019 оны 5 дугаар тогтоолын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багш, туслах багш, албан хаагчид олгох улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох” тогтоолд 2022 оны 252 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан,
- БШУС-ын 2022 оны А/170 дугаар тушаалаар батлагдсан “Хичээл, сургалтын үйл ажиллагааны зардлыг төлөвлөх, хуваарилах заавар”-ыг хэрэгжүүлж эхэлсэн,
- БШУС-ын 2022 оны А/465 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуульд, кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах нийтлэг журам”-ыг шинэчлэн баталсан,
- ХНХС-ын 2021 оны А/192 дугаар тушаалаар батлагдсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам” хэрэгжиж эхэлсэн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн зүгээс дотоод аудитын хяналт, шалгалт хийгдээгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан сумын Ерөнхий боловсролын 9 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дархан сумын Ерөнхий боловсролын 9 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 212,253.1 мянган төгрөгөөр буюу 5.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	229,171.8	229,171.8
Авлага		-	-
Бараа материал	92,002.0	96,977.8	4,975.8
Үндсэн хөрөнгө	3,502,542.5	3,480,648.0	(21,894.5)
Нийт хөрөнгө	3,594,544.5	3,766,797.6	212,253.1
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,594,544.5	3,806,797.6	212,253.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	3,594,544.5	3,806,797.6	212,253.1

Тайлант жилийн үйл ажиллагааны зардлын хэмнэлт 229,171.8 мянган төгрөгийг Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт “Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал”-ын 8.7-д “Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ.” гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 96,977.9 мянган төгрөг болж 4,975.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 59,500.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, БШУЯ-наас 9,260.5 мянган төгрөгийн үнэ бүхий 64 нэр төрлийн 2420 ш төлбөртэй сурах бичгийг захирлын 2022 оны А/65 тоот тушаалын бусад хангамжийн бараа материалыг үнэ төлбөргүй орлогоор бүртгэж, 42 нэр төрлийн 4,039.5 мянган төгрөгийн материалыг захирлын 2022 оны А/56 тоот тушаалыг үндэслэн актлагдсан бөгөөд үйл ажиллагаанд 59,745.4 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 4,152,449.7 мянган төгрөг болж 154,438.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 95,383.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, шалгалтын хариу засах программ хангамж худалдан авч, Сумын Засаг даргын 2022.10.12-ны А/191 тоот захирамжаар Дуу хөгжмийн бичлэгийн студи хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлж 3 хандиваар 5,000.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, аймгийн ОНӨГазрын

2022.11.17-ны А/16 тоот тушаалаар 1дүгээр сургуулиас 5 нэр төрлийн 388 ш 27,120.0 мянган төгрөг үнэ бүхий сурагч ширээ сандалыг шилжүүлэн хүлээн авч захирлын А/90 тоот тушаалын дагуу тавилга эд хогшил, аймгийн ОНӨГазрын 2022.11.17-ны А/15 тушаалын дагуу үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг сунгаж, үнийг шинэчлэн тогтоож дахин үнэлгээний нэмэгдэлд 9,339.4 мянган төгрөг үүнээс машин тоног төхөөрөмж 4,925.0 мянга, тавилга эд хогшил 2,847.5 мянга, бусад үндсэн хөрнгө 1566.9 мянган төгрөг, БШУЯ-наас гал тогооны тоног төхөөрөмж-40,000.0 мянган төгрөг, 10162.5 мянган төгрөгийн сурах бичиг ном хүлээн авч захирлын 2022 оны А/41, А/80 тоот тушаалын бүртгэлд авч холбогдох хууль тогтоомж, захирамж тушаал шийдвэрийн дагуу нийт 187,005.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө орлогод авч, Аймгийн ОНӨГазрын 2022.11.17-ны А/15 тоот тушаалаар 12.233.9 мянган төгрөг, Засаг даргын 2022.12.15-ны 01-А/344 тоот захирамжаар үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах зөвшөөрөлийн дагуу сурах бичиг 309 нэр төрлийн 11688 ш 20,333,6 мянган төгрөгийн сурах бичгийн акталж данснаас хассан нь шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,806,797.6 мянган төгрөг болж 212,253.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,497,277.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 88,554.6 мянган төгрөгөөр нийт зарлагыг 3,585,831.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас тэтгэвэр тэтгэмжийн зардлыг 238,521.5, бусад зардлыг 345,269.0 мянган төгрөгөөр бууруулж нийт төсвийг 3,002,041.4 мянган төгрөгөөр баталсан байна.

2022 оны 11 дүгээр сард бараа үйлчилгээний бусад зардалд 24,340.3 мянган төгрөгөөр төсвийг нэмж тодотгосноор улсын төсвөөс 2,880,710.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 127,092.5 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 18,578.9 мянган төгрөг нийт 3,026,381.7 мянган төгрөгийн эх үүсвэрийг баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 2,880,710.3 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 127,092.5 мянган төгрөг, төсөвт байгууллагын өөрийн орлого 18,578.9 мянган төгрөг нийт 3,026,381.7 мянган төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,786,733.4 мянган төгрөг буюу 92.01 хувьтай байгаа нь цалингийн зардлаас 140,834.2 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлд 15,678.9 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 10,310.9 мянга, хоол хүнсний зардлаас 225,7 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 9,676.6 мянга, бараа үйлчилгээний бусад зардал 40,964.7 мянган төгрөгийг тус тус хэмнэн, 14,170.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, 229,171.8 мянган төгрөгийн үлдэгдлээр тайлагнасантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр	д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	зөрүү	Биелэлт
1	71802 Ерөнхий боловсрол	1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	10,264.7	9,233.4	1,031.3	89.9
		2	80312- Сургалт семинар	5,132.3	3,557.0	1,575.3	69.3
		3	81605- Эрүүл мэндийг дэмжих	11,804.4	6,862.0	4,942.4	58.1
		4	81801- Үдийн цай хөтөлбөр	302,977.7	281,020.5	21,957.2	92.8
		5	81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	101,900.0	73,279.0	28,621.0	71.9
		6	81823- Боловсролын багшийн сургалт	23,095.5	21,675.4	1,420.1	93.8
		7	81834- Боловсролын стандарт сургалт	2,328,190.6	2,159,372.9	168,817.7	92.7
		8	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	97,345.1	96,599.1	746.0	99.2
		9	81844- Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	4,634.3	4,695.2	-60.9	101.3
		10	81848-Сурах бичгийн түрээс	10,344.6	10,344.6	-	100.0
		11	80111-120010	3,600.0	7,234.2	-3634.2	200.1
		12	80111- Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	84,954.6	74,417.9	10536.7	87.5
		13	80112- Нийтлэг үйлчилгээ	42,137.9	42,137.1	0,8	100.0
Нийт				3,026,381.7	2,790,428.3	235,953.4	92.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд хандив 4634.3, бусад орлого 845.0 сурах бичгийн түрээсийн орлого 10,340.9 мянган төгрөгийн орлого төвлөрснийг зохих дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дархан сумын Ерөнхий боловсролын 9 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын санхүүгийн сахилга батыг дээшлүүлж, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй, үр, ашигтай зарцуулахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Дархан Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу “ЦЭСБ-Аудит” ХХК-ийн аудитор Ч.Цэрэннадмид гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг аудитын менежер У.Батсүрэн, дарга, тэргүүлэх аудитор Ш. Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан сумын Ерөнхий боловсролын 9 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг ЦЭСБ-Аудит ХХК-д 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,087,515.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 20,875.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагатгүй гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Боловсролын ерөнхий газраас нийт боловсролын байгууллагуудад 2022 оны 04, 09 дүгээр саруудад төрийн хэмнэлтийн тухай хууль болон ЗГ-ын 2022 оны 203 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, төсвийн хэмнэлтийн горимоор ажиллах, орон тоог хязгаарлах, төрийн үйл ажиллагааг цахимжуулах, бараа үйлчилгээний зардлыг бууруулах, зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Ерөнхий боловсролын 9 дүгээр сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг дараах байдлаар хэрэгжүүлжээ. Үүнд:

- Боловсролын салбарын үр дүнд суурилсан санхүүжилтийг нэвтрүүлж батлагдсан орон тоогоор бус гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотойгоор цалин, ажил олгогчоос төлөх НДШ, үдийн цай хөтөлбөр, сургалт семинарын зардлаас нийт 229,171.8 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгожээ.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд боловсролын байгууллагын мэдээлбэл зохих 20 төрлийн 151 мэдээллээс огт мэдээлээгүй мэдээлэл байхгүй бөгөөд мэдээллийн хэрэгжилт 100,0 хувьтай байна.

Шийдвэрлэсэн нь: Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцэж байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

“ЦЭСБ-Аудит” ХХК-ийн 2022 оны 11 дүгээр 21-ны 206 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” захидлыг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар нийт 9,159.8 мянган төгрөгийн зөрчилд тогтоосон төлбөрийн акт, албан шаардлага, өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шалгахад 100 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган
төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	153.1	1	153.1	100.0
Албан шаардлага					
Зөвлөмж	3	9,006.7	3	9,006.7	100.0
Нийт дүн	4	9,159.8	4	9,159.8	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараах асуудал нь тухайн төсвийн захирагчийн бус дээд шатны төсвийн захирагчийн шийдвэрээр хэрэгжсэн учир Дархан сумын 9 дүгээр сургуулийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар зөрчлөөр тооцоогүй бөгөөд дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус бараа үйлчилгээний бусад зардалд бөөнөөр нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлыг бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Иймд төсвийг зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитын явцад тайлант онд Боловсролын яамны хөрөнгө оруулалтаар Чиглэл ХХК-аас 40,000.0 мянган төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмжийн санхүүгийн байдлын тайланд үндсэн хөрөнгөөр бүргэж орлого аван залруулага хийв.

Аудитаар нийт 6,193.2 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 877.3 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоон, 5,315.9 мянган төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өглөө.

5.1. Акт

1. Нягтлан бодогч Ц.Отгонцагаан 7 дугаар сард 745,6 мянга , бичиг хэргийн ажилтан Ц.Энхчимэг 3-р сард 131,7 мянга нийт 877,3 мянган төгрөгийн илүү цаг тооцож олгосон Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт 3.3 дахь” Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна”гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

1. Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

1.1 Илрүүлэлт: Тайлант онд 5,315.9 мянган төгрөгийн бичиг худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Гал тогооны тоног төхөөрөмжийн санхүүгийн байдлын тайланд үндсэн хөрөнгөөр бүргэж орлого аван	1	40,000.0	-	-	1	40,000.0	1	40,000.0	-	-	-	-
Дүн	1	40,000.0	-	-	1	40,000.0	1	40,000.0	-	-	-	-

